

ХИЛЧИН БАЙСНАА ДУРСАХЫН УЧИР

Сэтгэцийн эмгэг-мансуурлын төвийн захирал, Анагаах ухааны доктор, профессор Лувсандоржийн Эрдэнэбаяр одоогоос 25 жилийн тэртээ хилчин байсан үеийнхээ тухай манай сурвалжлагч Ш.Доржбалтай хөөрөлдсөнийг уншигчиддаа толилуулж байна.



Лувсандоржийн Эрдэнэбаяр.

Хүний их эмч, нийгмийн эрүүл мэндийн зохион байгуулагч, сэтгэцийн эмгэг - мансуурал судлаач мэргэжилтэй. ОХУ-ын Анагаах ухааны Академийн Сибирь, Алс Дорнодын Томскийн салбарт аспирантурт суралцаж, 1991 онд Анагаах ухааны дэд доктор, 1997 онд мөн институтэд шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан. Нэг сэдэвт зохиол, ном товхимол хориодыг, шинжилгээний бүтээл 85-ыг дотоод, гадаадад хэвлүүлжээ. Энэ онд “Мансуурал

судлалын үндэс” гарын авлага хэвлүүлээд байна.

Сурв- Таныг Хилийн цэрэгт алба хааж байсан гэж сонссон. Хилчин байлдагч байсан үеэ эргэн дурсах ч сайхан даа.

Л.Э- Миний амьдралын нэгэн чухал үе бол хилчин хэмээх алдрыг хүртэж хилд алба хаасан гурван жил минь. Шүлэг, найрагт суугаа цэнхэр Сулинхээр хэмээн магтан дуулдаг зэрэглээ хулан хоёр нь уралдсан тэр сайхан нутагт 1973-1976 онд цэргийн алба хаасан хүн дээ, би. Байлдагчаас ахлах түрүүч цолтой халагдсан.

Сурв: Та яг аль салбарт алба хаасан бэ?

Л.Э Хангийн заставт хэсэг хугацаанд алба хаасан. Ихэнх албаа отрядын төвд маневр ротын МХЗЭ-ийн нарийн бичгийн даргаар ажилласан. Ер нь ажил алба маань сайн дарга захирагч нарын түшиг дэмжлэгээр муугүй байсан шүү. 1975 онд Хилийн ба Дотоодын цэргийн удирдах газраас зарласан болзолт уралдаанд манай эвлэлийн үүр тэргүүн байр эзэлж, дурсгалын дарцаг, диплом, үнэ бүхий зүйлээр шагнуулж байсныг би мартдаггүй.

Сурв- Та ч тэгвэл сайн ажилтай эвлэлийн үүрийн дарга байж шүү дээ. Өөр шагнал урамшил чамгүй л хүртээ биз дээ?

Л.Э- Тэр үед эвлэлийн үүрийн нарийн бичгийн даргаар сонгогдоно гэдэг хамт олны итгэл найдварыг хүлээнэ гэсэн үг байв.

Тэргүүний гишүүд хилчдийн албаны амжилтыг түгээх, хоцрогсод, доголдол дутагдал гаргагчдыг хүмүүжүүлэх, тэргүүний хилчний эгнээнд хүргэх гээд нэг үгээр хэлбэл хилчин залуучуудыг сурган хүмүүжүүлэх сонгуульт ажлыг хийдэг байлаа.

Эндээс л би өөрийнхөө мэдлэг чадварыг дээшлүүлэхэд анхаарах хэрэгтэйг анхлан ухаарч, олон аавын хөвүүдтэй ам хэлээ ололцох, арга эвийг нь олоход суралцсан. би цэргийн 3 жилд орос хэлийг бие даан сурсан юм шүү дээ. Шагнал авч Л байсан. Гурван жил дараалан онц сурсан, онц буудагч, тэргүүний хилчин байлаа. Сониноос гэвэл ноднин жил намайг Хилийн Цэргийн командлагчийн тушаалаар "Онц хилчин" тэмдгээр шагнасан шүү дээ. Надад хилчний гурван жил их зүйлийг сургасан.

Сурв- Тэр үеийнхээ дарга нарын тухай дурсахгүй юу?

Л.Э- Отрядын дарга хурандаа Жанцан, Штабын дарга дэд хурандаа Бенжин, салбарын захирагч, эдүгээ хурандаа Д.Гончиг гээд Хилийн цэрэгтээ толгой цохидог шилмэл сайн дарга нарын ц эрэг явсандаа би ямагт бахархдаг.

Сурв- Таны алба ХАмт хааж байсан далаад оны Хилийн Цэргийг өнөөгийн Хилийн цэрэгтэй харьцуулахад ямар сэтгэгдэл төрж байна даа? Хилийн Цэргийн талаар таны бодол?.

Л.Э- Их өөрчлөгдсөн нь мэдээж. Төр засгаас ч урьдын адил анхааран дэмжиж байдагт нь хилчин байсан хүний хувьд баярладаг. Ер нь би ХЦ-ийн талаар чих тавьж, сайн сайханд нь баярлаж, саар зүйлд нь харамсаж явдаг юм.

Миний алба хааж байхад цэргийн тоо одоогийнхоос олон, алба хаах хугацаа гурван жил байсан. Одоо нэг жил болгосон нь хэр оновчтой юм бол. Үгүй дээ 2.5 жил Хилд алба хаадаг баймаар. Сургууль соёл төгссөн, ёс суртахууны доголдолгүй Тийм залуусыг Хилийн цэрэгт авдаг байсан санагдана. Гэтэл одоо ч бичиг үсэг мэдэхгүй, нэрээ ч тавьж чадахгүй хүмүүс ирдэг болжээ. Тэгээд бас хүмүүжлийн доголдолтой ийм залуус яаж хилд алба хаах юм бэ?

Бидний үед МХЗЭ-ийн үүрээс эхлээд Сүхбаатарын тасалгааны зөвлөл, ухуулагч нар, эмэгтэйчүүдийн хэсэг гээд олон байгууллага, сонгуульнууд, хилийг сургаж хүмүүжүүлэх, албаа сайн хаахад захирагч дарга нарт тус дэм болж ажилладаг байсан. Ингэж ажиллахыг шаарддаг ч байсан. Гэтэл одоо сураг сонсоход цаг үеэ дагаа юм байлгүй энэ бүхэн алга болж, зөвхөн хэдэн дарга офицер нь л хөөцөлдөж, үүнийхээ төлөө цэрэгтээ буудуулж байдаг нь харамсалтай. Иймээс ХЦ-т дайчдад боловсол олгох сургалт соёл хүмүүжлийн ажлыг шинэ шатанд гаргах хэрэгтэй юм болов уу даа.

Мөн хилчдийг мэргэжлийн болгох, ХЦДС-ийг улам бэхжүүлэх, хилчдийн нийгмийн асуудлыг төрөөс зориуд анхаарч цалинг нь нэмэгдүүлэх гэхчилэн олон санал тавьж болох байна.

Сурв- Таныг мэргэжлийн талаар ганц асуулт тавья. Сэтгэцийн эмгэг, мансуурал судлалаар хорин жил хөдөлмөрлөн олон бүтээл туурвижээ. Саяхан хэвлэгдсэн "Мансуурал судлалын үндэс" номоо бичих болсон шалтгаан юу вэ?

Л.Э- Хоёрхон сая хүн амтай, бүх хүний 70 орчим хувийг 35 хүртэлх насны залуучууд эзэлдэг Монгол Улсын хувьд мансуурах дон, архинд донтох өвчин нэлээд түгээмэл тархсан нь хүний эрүүл мэндэд хэзээ ч нөхөж баршгүй хохирол учруулаад зогсохгүй амьдралын сайн сайхан бүхнийг үгүй хийж, нийгмийн дэг журмыг гажуудуулах, гэмт хэрэг үйлдэхийн гол шалтгаан болж байна. Мансуурал судлалын чиглэлээр манайд өмнө нь нийтлэгдэж байсан цөөн бүтээлүүд нийгмийн эрүүл мэндийн орчин үеийн онолын үндэслэлд тулгуурлаагүй, аль хэдийн патоморфоз болчихсон эмнэл зүйг барьсан явцуу хүрээнд бичигдсэн учраас өнөөгийн нийгмийн цар хүрээ, эрэлт хэрэгцээ, шаардлагад уг асуудлыг шийдвэрлэх онолын үндэслэл болж өгөхгүй байгаа юм.

Мөн одоогийн залуу эмч мэргэжилтэн, оюутан судлаачид, хуульчдад мансуурал судлалын чиглэлээр гарын авлага нэн ховор байгаа зэргээс санаа авч бичсэн юм.

Сурв: Хилчин байсан үеэ дурсаж хуучилсан танд их баярлалаа. Яг энэ мөчид хил дээр алба хашиж яваа хилчиддээ хандаж юу хэлмээр байна?

Л.Э. Монгол орны хэн ч халдашгүй дархан хил дээр ард түмнийхээ сайн сайхны төлөө үүргээ нэр төртэй биелүүлж байгаа эрэлхэг хилчиддээ сонор соргог байж, хилчин хэмээх алдрыг ямагт өндөрт өргөж яваарай гэж захъя.



Манай сурвалжлагч